

**ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН “ЕРӨНХИЙ МЭРГЭШИЛ СУДЛАЛ” ЧИГЛЭЛЭЭР ТӨГСӨЖ,
БУСАД ЧИГЛЭЛИЙН СУРГАЛТАД ҮРГЭЛЖЛҮҮЛЭН СУРАЛЦАХ
ЭЛСЭГЧДИЙН ЯРИЛЦЛАГА ШАЛГАЛТЫН ЗААВАР**

Нэг. Шалгалтын агуулга:

1. Хууль, эрх зүйн мэдлэгийн асуулт – 40 оноо
Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиас 2 асуулт ирнэ. Асуулт тус бүр 20 оноогоор үнэлэгдэнэ.
2. Ёс зүй, харилцаа хандлагын асуулт- 60 оноо

Эмч мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, бүтээлч сэтгэлгээ, багаар ажиллах чадвар зэргийг тодорхойлох 10 асуултаар ярилцлага хийнэ. Асуулт тус бүр 6 оноогоор үнэлэгдэнэ.

Хоёр. Шалгалтын бэлэн байдал:

- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 1-р байранд 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр 10:00 цагт эхлэнэ.
- Хуваарийн дагуу танхимд товлосон цагт ирсэн байна.
- Иргэний үнэмлэх, шалгалтын төлбөр төлсөн баримтыг авч ирнэ.
- Шалгалтын танхимд орохын өмнө дэвтэр, гар утас, зөөврийн компьютер зэрэг эд зүйлсийг биедээ авч орохыг хориглоно.
- Шалгалтын байранд байршуулсан дуугүй хөтөчийн дагуу шалгалт өгөх хуваарьт танхимд очно.
- Комиссын гишүүдийн санамсаргүй сонголтоор хуваарилсан ширээнд сууж, шалгалтын зааврыг анхааралтай сонсож, өөрийгөө бэлдэнэ.
- Ярилцлага шалгалтын үргэлжлэх хугацаа 15 минут байна.
- Шалгалтыг хугацаанаас нь өмнө дууссан тохиолдолд шалгалтын комиссын гишүүнд мэдэгдэж, бусдын анхаарлыг таталгүй танхимаас гарч болно.

Гурав. Шалгалтын төлбөр төлөх заавар:

- Хүлээн авагч банк, дансны дугаар: Төрийн сан, 100900020020
- Дансны нэр: Эрүүл мэндийн хөгжлийн төв
- Гүйлгээний утга: Үндсэн мэргэшлийн элсэлт /Овог, нэр, регистрийн дугаар/
- Шалгалтын төлбөр: 10,000 төгрөг
- Төлбөрийг банк, интернэт банк болон ЭМХТ-ийн 1 давхарт байрлах автомат машинаар төлөх боломжтой.